


# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


## НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-27 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1328** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



### Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1328 тохиолдлын 94% /1249/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /78/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /2/, Баянхонгор /1/ ) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **367** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

## ЭПИДЕМИОЛОГИЙН 27 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.06.29 – 07.05)

2025 оны эпидемиологийн 27 дугаар долоо хоногт 1 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 66.7 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 97.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



### ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ


Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд эпидемиологийн 1-27 дугаар долоо хоногт нийт **693** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.

**403**  
Эмнэлгийн тусламж авч буцсан

**290**  
Хэвтэн эмчлүүлж эдгэрч гарсан


**0**  
Нас барсан

Эрэгтэй **45%**  
Эмэгтэй **55%**



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 27 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **24** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 2 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 27 долоо хоногт)

| №           | Шалтгаан (Сэдэл)        | Санаатай  | Санамсаргүй | Нийт      |
|-------------|-------------------------|-----------|-------------|-----------|
| 1           | Химийн бодисын хордлого | 3         | 8           | 11        |
| 2           | Эмийн хордлого          | 11        | 2           | 13        |
| <b>Нийт</b> |                         | <b>14</b> | <b>10</b>   | <b>24</b> |

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд шалтгаанаар нь авч үзвэл амиа хорлох сэдлээр олон тооны эм хольж уусан байна.

-ооо-